

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть L (626)

<https://doi.org/10.22353/ms20255015>

МОНГОЛ ДОМОГ ЗҮЙ ДАХЬ НОХОЙНЫ ДҮР, БЭЛГЭДЭЛ

Г.Нандинбилиг

Хураангуй: Энэхүү өгүүлэлд нохойтой холбоотой монгол хэлцүүдийн утгыг домог зүйн өгүүлэмжээр тайлан тайлбарлах замаар монгол домог зүйд нохойг хэрхэн бэлгэддэг талаар авч үзэж, тайлан тайлбарласан болно. Монгол домог зүйд дүрсэлснээр нохой бол сэрэмж алдсаны учир хүний өмнө өр төлөөстэй болсон домог зүйн архетип дүр юм. Монгол домог зүйд нохой нь хүний өмнө амин насны өр төлөөстэй, хүний тусын тулд хүчин зүтгэж чадвал нохойн төрлөөсөө чөлөөлөгдөж, хүний төрөлд дэвших босго болзлыг үүрч яваа адгуус гэж дүрслэгддэг. Ертөнцийн үүслийн домгуудад хүнийг бүтээн туурвих явцад өрнөсөн Бурхан, Чөтгөр хоёрын хоорондын зөрчил, тэмцлийн дунд нохой нь өртөж хэлмэгдсэн бөгөөд нохой нь хүнийг Чөтгөрөөс хамгаалах үүрэгтэй бүтээгдсэн ч сэрэмж алдсан тул Бурханд шийтгэгдсэн дүр байдаг.

Нохойг гаршуулахын хэрээр домог зүйн дараагийн улирал хувиралд шар зүсмийн нохой нь нийгмийн статусын бэлгэдэл болж, язгууртны соёлтой гүнзгий холбогдсон байна. Хүн, нохой хоёрын харилцаа хөгжих хэрээр домгийн нохой нь ёс заншлын нохой болж, нохойн дүрийн бэлгэдэл улам баяжсан ба монголчууд нохойгоор эзнээ хамгаалах сонор сэрэмж хийгээд үнэнч зан байдлыг бэлгэдэх болжээ.

Түлхүүр үг: Монгол, домог, нүүдэл, нохой, бэлгэдэл

Keywords: Mongol, myth, dog, nomadism, symbolism

Судлагдсан байдал

Монгол нохойг археологи, антропологийн эрдэмтэд голлон судалжээ. Монгол нохойтой холбогдох нийгэм, хүмүүнлэгийн судалгаа гэвэл Их Британийн антропологийн нэрт эрдэмтэн Каролин Хамфригийн (1976) “Some notes on the role of dogs in the life of Mongolian herdsmen” өгүүлэл¹, Б.Бадма-Оюугийн (2011) “Монголчуудын тотем шүтлэг” (Нохой тотемийн хэрэглэхүүнээр) докторын диссертаци, Францын эрдэмтэн Изабелле Бианке, Франсуа Обен, МУ-ын эрдэмтэн С.Дулам нарын (2013) хамтран бичсэн “Le chien et la bru, deux être liminaires en Mongolie” /Нохой ба бэр: Монгол дахь хоёр хязгаар/² өгүүлэл, Габи Баманагийн

¹ Humphrey, C. 1976. Some notes on the role of dogs in the life of Mongolian herdsmen. *Journal of the Anglo-Mongolian Society* 3(2): 14–23. Humphrey, C. (2013) discussed the dog in a paper which she presented at a workshop on ‘The Hiccups of Social Life’ in Cambridge in May 2013.

² Bianquis, I., F. Aubin & D. Sedenjav. 2013. Le chien et la bru, deux être liminaires en Mongolie, in K. Buffetrille, J.-L. Lambert, N. Luca & A. de Sales (eds.), *D’une anthropologie du chamanisme vers une anthropologie du croire. Hommage à l’œuvre de Roberte Hamayon: 303–323.* (Etudes mongoles et sibériennes, centrasiatiques et tibétaines, hors-série.) Paris:

(2014)³ “Dogs and Herders: Mythical Kinship, Spiritual Analogy, and Sociality in Rural Mongolia” /Нохой ба малчид: Домог зүйн ураг төрлийн холбоо, сүнсний зүйрлэл ба Монголын хөдөөгийн нийгэмшил” өгүүлэл, Т. Баасанжавын (2015) бичсэн “The Mongolian Dog as an Intimate ‘Other’ /Дотно “Бусад” шиг монгол нохой/ өгүүлэл⁴, Г.Батболдын (2020) бичсэн “Нүүдэлчдийн нохой” (Нэн эрт, Хүннү, Эртний улсуудын үе) ном зэрэг гарч, түүх, археологи, антропологийн талаас судалгаа давшингүй өрнөж байна.

К.Хамфри 2013 оны 5-р сард Кембрижд болсон ‘Нийгмийн амьдралын зовиур’ сэдэвт семинарт тавьсан илтгэлдээ монгол нохойг “бусдын дотно” гэж тодорхойлоод монгол нохойг бусад амьтдаас хэд хэдэн талаараа ялгаатай гэж үздэг. Нэгдүгээрт, нохойн тухай нийтлэг ойлголт нь тэднийг цагираг, шоргоолжны төрөл зүйл биш харин хувь хүн гэж үздэг. Хоёрдугаарт, хүний орон зайд энгийн нэвтрэн орох нь асуудал байж болохгүй, учир нь нохдыг ариун бус гэж үзэж, гэрт оруулахгүй гэж үздэг ч тэдгээр нь яг тэр орон зайг хамгаалагч бөгөөд гэрийн хүний өргөн хүрээний хүрээнд зайлшгүй чухал үүрэг гүйцэтгэдэг. Гуравдугаарт, нохой нь хүний нутаг дэвсгэрт амьдардаг тул тэдний үйлдэл нь зөвхөн өөрсдөдөө хамаарахгүй, харин эзэд, дайснууд болон бусад элементүүд, жүжигчидтэй холбоотой байдаг. Эцэст нь хэлэхэд, нохойнууд нь үнэнч, эр зориг, алсын хараа гэх мэт санаа бодол, ёс суртахууны шинж чанартай байдаг. (Humphrey 2013)

Т.Баасанжавын (2015) бичсэн “Дотно “бусад” шиг монгол нохой” хэмээх өгүүлэлд нохойг үзэх монголчуудын уламжлалт ойлголтоос эхлээд социализмын үеийн байдал, цаашлаад социализмын дараах Монголын үндсэрхэг үзэл сурталд нохойн гүйцэтгэсэн үүргийн тухай өгүүлсэн байна. Тэрээр монголчуудын нохойд хандах хандлага нь хоорондоо зөрчилддөг гээд энэ нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхдээ Кэролайн Хамфри, Виктор Тернер нарын “дотно бусад” гэдэг санааг ашигласан байна.

Г.Батболдын (2020) “Нүүдэлчдийн нохой” (Нэн эрт, Хүннү, Эртний улсуудын үе) номд нохойн гарал угсаа, уугуул төрх байдлыг түүх, археологийн баримтад тулгуурлан сурвалжийн мэдээгээр бататгаж, угсаатан зүй, хэл шинжлэлийн баримтуудад түшиглэн домог, туульст буй өгүүлэмжүүдийг судлан шинжилж тодруулахыг зорьжээ. Энэ бүтээл нь хоёр дэвтрээс бүрдэх бөгөөд нэгдүгээр дэвтэр нь нэн эрт, хүннү, эртний улсуудын үед хамаарах бол хоёрдугаар дэвтэрт, Чингис хаан ба түүний залгамжлагчдын үеийн нохойны гарал угсааны түүх байх ажээ.

Дээрх судалгаануудад монголчуудын нохойг үзэх зөрчилтэй үзэл хийгээд хүн нохой хоёрын харилцааны тухай бичсэн ч нохойг аман зохиол, домог зүйн нэг уран дүр болох талаас нь хараахан бичээгүй байна. Иймээс би өмнөх хүмүүсийн авч яриагүй нохойтой холбоотой ёс заншил, хэлц, хэллэгүүдийн утгыг тайлбарлах замаар нохойн тухай ертөнцийн үүслийн домгууд дахь нохойн дүр хийгээд бэлгэдэл утгыг тодруулах болно.

Centre des Etudes Mongoles & Sibériennes/Ecole Pratique de Hautes Etudes.

³ Bamana Gaby 2014. Dogs and Herders: Mythical Kinship, Spiritual Analogy, and Sociality in Rural Mongolia. SINO-PLATONIC PAPERS, Number 245

⁴ Baasanjav, T. 2015. The Mongolian Dog as an Intimate ‘Other’. Article in Inner Asia · April 2015

Нэг. Нохой - хүний өсөрхөг мөн чанарын бэлгэдэл болох нь

“Үхэр унасан хүнд нохой өшөөтэй...” хэмээх үгийн учир

Ертөнцийн үүслийн монгол домогт нохой бол хүний бие эрхтнээс тасарч бүтсэн гэж үзүүлдэг. Хүний үүслийн тухай домгийн нэгэн хувилбарт *“Эрт цагт Бурхан багш шавраар хоёр хүн хийж тавьчхаад юманд яваад ирэх хооронд нь үхэр эврээрээ эгэм руу нь сээжээд хэсэг шавар эмтлээд унагачихсан гэнэ. Тэр эмтэрч унасан шавар нь нохой болсон юм байж. Нохой уг нь эрдэнэт хүний бие олох сайхан заяатай байтал үхэр түүнээс салгаж нохой болголоо гэж үхэрт өсөрхдөг болсон хэрэг биз. (МАДҮ., 1989, 91) Монголчууд “Үнэн үг хэлсэн хүнд хүн өшөөтэй, үхэр унасан хүнд нохой өшөөтэй”, “Ноёнтой өстэй хүн толгойгүй, нохойтой өстэй хүн хормойгүй” гэхчлэн хэлц үг гарсны учир энэ гэнэ.*

Энэ домогт хүн язгуур мөн чанараасаа өөрт тустай үнэн зөв үгийг хүлээж авах чадваргүй, үнэнийг хэлсэн хүнд өширхөж байдаг гэсэн хүний мөн чанарын талаарх ажиглалтаа нотлохдоо нохойн дүрийг сонгож авсан байна. Чингэхдээ хүн болох боломжийг нь алдуулсан үхэрт нохой хамгаас их өширхдөг гэсэн домог зүйн уран сэтгэмжээр дамжуулан, нохой нь хүний эгэмнээс эмтэрч унасан учраас хүн, нохой хоёр бол өсөрхөг зан чанартайгаараа адил юм гэсэн байдлаар хүний өсөрхөг мөн чанарыг нохойгоор бэлгэдэн үзүүлсэн байна. Амьдрал дээр морьтой хүнийг хараад нүд дассан нохой нь үхэр унасан хүн харахаараа гаж жигтэй санагдаад ихэд боргоон хуцдаг билээ.

Харин дараагийн унших домог нь нохойн үсийг бузар гэж цээрлэх ёсны далд утгыг тайлбарлах боломжийг өгч байна.

Хоёр. Нохой - өлөн ховдгийн шийтгэлийн бэлгэдэл болох нь

“Муурын хэл бузар, нохойн үс бузар” хэмээхийн учир

Нохой бол энэ төрөлдөө эзэн хүндээ үнэнч нөхөр нь байхаар Бурханаас даалгавартай бүтээгдсэн амьтан бөгөөд тэгж чадвал дараагийн төрөлдөө хүн болж дахин төрөхийн босгон дээр байгаа амьтан юм. Монгол аж байдлын дүр зургийг нүдээр харсан хэн хүнд монгол нохой нь ихэнхдээ гэрийн үүдэнд, босгоны гадаа эзнээ сахин хэвтэж байгаа дүр зураг нүднээ тодхон бууна. Домог зүйн уран сэтгэмжийн хувьд хүн, нохой хоёр бол ертөнц бүтээгдсэний дараа анх хамт бүтээгдсэн бөгөөд нохой нь хүнийг Чөтгөрийн хорлолоос хамгаалах зорилгоор бүтээгдсэн амьтан байжээ. Гэвч эзнээ хамгаалж чадалгүй, ховдгоосоо болж сэрэмж алдсан тул Бурхнаас түүнд шийтгэл хүлээлгэж, хүнд өр төлөөстэй амьтан болгосон байна. Жишээлбэл: хүний үүслийн домгийн халх хувилбарын тухайд өгүүлэмжийнх нь гол үс гэвэл Бурхан хүнийг бүтээх гэж шавраар эр, эм хоёр хүний дүрс хийгээд амилуулах мөнхийн рашаанд явсан хойгуур Чөтгөр хорлох магадгүй гэж нохой, муур хоёроор өнөөх хоёр шавар хүнийг сахиулсан тухай өгүүлдэг. Домогт *“...Та хоёр, энэ хоёр хүнийг сайн харж бай! Намайг мөнхийн рашаан авчиртал амьтан бүү хавьтуул! Энэ хоёр, та хоёрын эзэн болж ивээх тул хичээж сайн харж сахиж бай!”* гэжээ. Тэгээд бурхны явсан хойгуур чөтгөр, бурхны туурвилыг хорлох гэж иртэл нохой муур хоёр нь хавьтуулахгүй байжээ. Тэгэхлээр нь чөтгөр, мууранд сүү, нохойд мах авчирч өгөөд идэж байх хооронд нь хоёр шавар хүн рүү эргэн тойрон шээж бузарлаад яваад өгч гэнэ. Бурхан мөнхийн рашаан авчирч хоёр хүнийг амь оруулах гэтэл үс нь бузартсан байсанд бурхан

хилэгнэж, муурыг хүний энэ үсийг зулба долоогоод арилга гэв. Муураар зулба долоолгож цэвэрлүүлсэнд гагцхүү толгойн үсэнд чөтгөрийн шээс хүрсэнгүй тулд үлдээлгээж, мөн суга цавинд муурын хэл хүрээгүй газарт бага сага бузар үс үлдээж гэнэ. Чөтгөр шээсэн бузар үсийг нохойд тохож гэгээн цээрлүүлсэн гэнэ. Иймээс хүн нүцгэн болж, нохой үстэй болсон гэнэ. Мөн үүний шалтгаанаар муурын хэл бузар, нохойн үс бузар гэж хэлэлцдэг ба хүн чөтгөрийн хорлолоор бузартсан учир бурхан хүний аманд мөнхийн рашаан дусаасан боловч хүн мөнх наслахгүй зуурдаар үхдэг болов” (Гаадамба, Цэрэнсодном 1978, 139-140) гэж гардаг. Мөн домгийн буриад хувилбарт Шибэгэни бурхан нохойд хилэгнэн уурлаж, “Хүйтэнд яс мэргж, хүний муу сайныг идээж, зодуулж яв ” гэж зүхсэн гэдэг. бол өөр нэгэн халх хувилбарт Бурхан нохойд хилэгнэж, “Нүүхэд явган дагаж, нүцгэн яс мэргж яв”, “Саранд сэрж, наранд дулаацаж яв” гэж шийтгэсэн гэж ярьдаг.

Гурав. Нохой –сонор соргогийн бэлгэдэл болох нь

Нохой бол нэг удаа сэрэмж алдаад шийтгэгдсэн тул энэ төрөлдөө сонор соргог байж, хүнийг хамгаалах тангарагтай, хүний өмнө төлөөсөө төлж яваа дүр юм. Дээрх домгийн нэг гол санаа нь нохой өлөн ховдгоосоо болж сэрэмж алдаад, ямагт гадаа хүйтэнд яс мэргж, нүүхэд явган дагаж, шөнө унтахгүй эзнээ сахиж явахаар шийтгэгдсэн гэсэн санаа байна. Тодруулбал, нохой нь энэ төрөлдөө дараах гурван шийтгэлийг үүрч яваа амьтан юм. Үүнд:

1. Нохой нь энэ төрөлдөө сонор сэрэмжтэй байж, эзнээ хамгаалж, шөнө унтахгүй байх тангарагтай

2. Нохой нь энэ төрөлдөө нүүдлийг явган дагаж, нүцгэн яс мэргж, хүний муугаар хооллож амьдрах шийтгэлтэй

3. Нохой нь энэ төрөлдөө гэрт орохгүй, гадаа амьдрах шийтгэлтэй

Домгийн ёсоор нохой нь дээрх гурван үүргийг сайн биелүүлж чадвал энэ төрлийнх нь шийтгэл дуусаж, дараагийн төрөлдөө хүн болж төрөх боломж бүрдэх ажээ. Мөн эндээс “Нохой явган, гахай нүцгэн” гэсэн хэлц үг гарсан ба нохой нь “явганы бэлгэдэл” болох нь ч бий. Нохойг гэрт тэжээдэггүйн учрыг ч мөн домгоор тайлдаг болно. энэ тухай дараагийн хэсэгт өгүүлье.

Дөрөв. Нохой-гэрийн соёлын бэлгэдэл болох нь

“Эсгий хийх газар нохой хэрэггүй” хэмээхийн учир

Нохойны үсийг бузар гэж сэжиглэх энэ заншлын цаана монголчуудын гэрийн соёлоос үүдэлтэй гэрт ба гадааг ялгах үзэл сэтгэлгээ, тодруулж хэлбэл, нохойг гэрт оруулж тэжээхийг хориглосон маш том цээрийн цаана монголчуудын гэрийн соёл байгаа болно. Монгол үлгэрт “Гэрт ч биш, гадаа ч биш” гэж бэрх болзол гардаг. Энэ нь гэрт байвал хүн, гадаа байвал нохой гэж ялгаж буй домгийн архетиптэй холбоотой.

Ертөнцийн үүслийн домгийн халх хувилбарт ертөнцийн гурван бузар зүйлд Чөтгөрийн шээс, муурын хэл, нохойн үс гурвыг нэрлэж байна. Домогт үзүүлснээр нохой бол Чөтгөрийн өгсөн үмх маханд хууртан сэрэмж алдаж, хүний мөнх наслах боломжийг үгүй хийсэн тул Бурханаас шийтгэгдэж, Чөтгөрийн шээсээр бузарлагдсан хүний үсийг нөмөрч яваа дүр юм.

Домгийн энэхүү уран санаанаас үүдэн монголчууд нохойн үсийг хамгийн бузар гэж цээрлэн цэрвэж, нохойн үстэй холбоотой янз бүрийн цээр, дом хийгээд ёс заншлыг бүтээжээ. Эдгээрээс монгол даяар нийдэм тархсан нэг заншил нь

монголчууд эсгий хийх өдрөө нохойгоо сайтар уядаг заншилтай байсан бөгөөд энэ заншлыг тусгаж “*Эсгий хийх газар нохой хэрэггүй*” гэсэн хэлц үг уламжилсан байдаг. Учир нь хонины ноосон эсгийгээр гэрийн дээвэр, туурга, өрх зэргийг урладаг тул хэрвээ эсгийнд нохойн үс орвол нохой гэр дээр гарсантай адил муу ёрын хэрэг болно гэж болгоомжилдог. Монголчууд нохойг гэрт оруулахыг цээрлэхээс гадна бас нохой гэр дээр гарахыг маш их муу ёр гэж үзэж, хэрвээ нохой гэр дээр гарсан тохиолдолд гэрийн эзний амь насанд цөвтэй гэж үзэж, заавал алдаг ёстой байжээ. Энэ нь бидний бодлоор нохойг араатай соёотой амьтан болохынх нь хувьд гаршуулж номхруулсан эзнээсээ буюу хүнээс айдаг болгож сургах нохой сургалтын уламжлалт аргатай холбоотой ёс байна. Нохой гэр дээр гарвал буудаж алах ёсыг гүн ухаж үзвэл “нохой эртэн” эмэгтэйчүүдийн тухай домогтой ч холбогдох юм.

Нохойг гэр дээр гарснаас бусад тохиолдолд нохойг алах болон зодох цээртэй. Учир нь нохой хүн хоёрын яс, цус хоёр нэг эхлэлтэй тул нохой алах нь хүн алсны ижил нүгэлтэй. Социализмын өмнөх үеийн Монголын иргэний амьдралын бүхий л асуудлыг зохицуулж байсан 1702 оны Халх журам хэмээх иргэний хуульд нохой алахыг хатуу хориглодог байжээ (Арьяасүрэн & Нямбуу 1991: 156, Жамцарано 1965).

Тав. Нохойн үхэл - хүний амин насны бэлгэдэл болох нь
“Сайн нохойн үхэл эзнээ хаадаг” хэмээх үгийн учир

Нохойг гэрийн эзний амь насны хамгаалагч, гэр бүлийн нэг гишүүн гэж бэлгэддэг. Нохой бол сэрэмж алдаж, хүний мөнх наслах боломжийг үгүй хийснийхээ хариуд хүнд амин насны өртэй болжээ. Нохой хүн хоёрыг холбож буй домог зүйн уран сэтгэмжээс үүдэн, монголчуудын дунд гэрийн тэжээвэр нохойн үхэл нь гэрийн эзний үхлийг хааж байдаг гэх итгэл үнэмшил буй болж, “Сайн нохойн үхэл эзнээ хаадаг” хэмээх үг өнөөг хүртэл уламжилж ирсэн байна.

Нохой өвдвөл эмчилдэггүй, сайн нохой эзнээ хааж үхдэг гэдэг. Нохой үхэхэд эзэд нь харамсан гашууддаггүй ёстой. Энэ нь нохойн хувьд хүний өмнө өр төлөөсөө амиараа төлж, хүний төрөлд дэвших боломж бөгөөд нохойн төрөлд амьдарсан шийтгэл нь дуусаж, зуурдын амьдралаас чөлөөлөгдөж, дараагийн төрөлдөө хүн болж төрөх учиртай. Чухам энэ итгэл үнэмшлээр нохой үхэхэд эзэн нь олж, аманд нь өөх үмхүүлж, сүүлийг нь тасдан оршуулж, хүн төрлөө олоход нь туслах ёстой. Энэ тухай И.Бианке нар болон Баасанжав зэрэг судлаачид бичихдээ “*Нохойд хандах монголчуудын хандлага бол хүн төвтэй. Нохой нь хүнтэй төстэй олон шинж чанартай төдийгүй Буддын шашинтай монголчууд хойд дүрийн тойрогт хүнтэй хамгийн ойр байдаг амьтан гэж үздэг. Өөрөөр хэлбэл, ардын итгэл үнэмшлийн дагуу нохой нь араатан амьтдын болон хүний сансар огторгуйн ертөнцийн хоорондох зуучлагч үе шатыг эзэлдэг. Хүн болж төрөхийн тулд бүх амьд амьтан эхлээд нохой болох ёстой. Зөвхөн нохой л дараагийн амьдралдаа хүн болж дахин төрөх боломжтой. Эсрэгээр, нүгэлт амьдралаар амьдарч байсан зарим хүмүүс дараагийн хойд төрөлдөө нохой болж доройтож, эцэст нь хүний төрөлтийг олж авах боломжтой гэж үздэг. Тиймээс монголчууд нохойг үхэхэд хүн төрөлхтөнд бэлтгэхийн тулд сүүлийг нь огтолж (Bianquis 2013: 311) толгойн доор нь дэр болгон тавьдаг нь нохой байхаа больсныг бэлгэддэг. Нохой нь сүнслэг болон орон зайн хувьд хүмүүсийн ертөнцтэй ойр байдаг тул нас барсан хүмүүс ихэвчлэн гэр бүлдээ нохой болон буцаж ирэхийг сонгодог гэж түгээмэл үздэг. Хамаатан садныхаа холбоог таслах ёстой лам нар ихэвчлэн төрөл төрөгсөддөө биш, сүм*

хийддээ нохой шиг буцаж ирдэг. Мэдээжийн хэрэг, хойд төрөл нь гэнэтийн зүйл биш юм. Хэрвээ талийгаач гэр бүлдээ нохой болон буцаж ирэх боломжтой бол эсрэгээрээ байж болно. Үхсэн нохой эзэндээ хүүхэд шигээ буцаж ирж магадгүй (Баасанжав, 2015:145) гэхчлэн бичжээ.

Нохойг хэрхэн оршуулах тухай домогт өгүүлэхдээ “Нохойг үхэхээр нь сүүлийг нь таслан авч, аманд нь хонины хэрчим сүүл юм уу шар тос үмхүүлдэг нь эргэж төрлөө олоосой гэсэн хэрэг юм. Нохой үхэхдээ хүн төлөөлж үхдэг учраас түүнийг үхлээ гэж эр хүн гасалдаггүй ажээ... Хүнээс нохой тасарч унасан болохоор хүний яс, нохойн яс хоёр адил гэж хэлдэг. Тэгээд хүний ясны бэртэнгэд нохойн яс сайн гэдгийн учир тэр юм байна. МАДҮ., 1989, 91 гэж тайлжээ. Анх өгүүлсэн домогт нохой нь хүний эгэмнээс эмтэрч унасан тул хүн нохой хоёрын яс адил бүтэцтэй гэж домоглож байсан бол энэ домог нь ясны бэртэнгтэй өвчтөнд анагаахад нохойн ясыг уулгах ардын уламжлалт эмнэлгийн мэдлэгтэй холбогдож байна. Мөн хүний үүслийн домгийн халх хувилбарт анх нохой нүцгэн, хүн үстэй байснаар дүрсэлж, Чөтгөр шээж бузарласны дараа хүний бузаргасан үсийг нохойд нөмөргөж, нохой үстэй, хүн нүцгэн болсон байдлаар домоглох замаар нохой, хүн хоёрын үс нь адил бүтэцтэй гэсэн санааг дамжуулсан бол энэ домогт нохой нь хүний эгэмнээс эмтэрч унасан тул хүн нохой хоёрын яс адил хэмээн домоглож, ясны бэртэнг өвчнийг анагаахад нохойн ясыг буцалгаж уулгах ардын уламжлалт эмнэлгийн мэдлэгийг домог зүйн үндэслэлээр тайлбарласан байна. Мөн хүүхэд шүдлэхэд монголчууд хүүхдийн сүүн шүдийг өөхөнд боон, нохойд өгч, сайн ясан шүд өгөхийг гуйдаг дом ч буй. Энэ нь мэдээжээр яс иддэг нохойн яс нь кальци сайтай байсныг ажигласан ажиглалтын мэдлэг болно. Энэ дашрамд өгүүлэхэд монголчууд зөвхөн өвсөн тэжээлтний мах идэж, араатай соёотой махчин амьтны махыг идэхийг цээрлэдэг уламжлалтай ч нохойн махыг уушигны өвчинд сайн гэлцэх нь байдаг.

Зургаа. Монгол нохойн зүсний бэлгэдэл

Хүн, нохой хоёрын харилцаа хөгжиж, анч ба хоточ нохойн үүрэг хэрэглээ ялгарахтай зэрэгцэн нохойн тухай соёлын дүрслэл улам боловсронгуй болсон. Нохойны зүс хийгээд нэрээр бэлгэдэх, нохой нь эзнээ хамгаалах сонор сэрэмж хийгээд үнэнч зан байдлыг бэлгэдэх болжээ. Монголчуудын эрхэмлэдэг монгол нохойн үндсэн зүс бол банхар нохойн дөрвөн нүдтэй халтар, зүрх цагаан хар нохой хоёр юм.

Дөрвөн нүдтэй халтар нохой - далдын үзэх бэлгэдэл

Монгол айлын мал идээ адгуулах хоточ нохойн гол зүс бол “далдыг үзэгч, бэрхийг сахигч” бэлгэдэлтэй дөрвөн нүдтэй халтар нохой юм. Хар халтар нохой нь хот айлыг чоно болон хулгайгаас хамгаалахын зэрэгцээ хий хийсгэлэн юмсыг ч харж хуцан үргээж байдаг гэж хэлэлцдэг.

Монголчууд монгол нохойны шар болон хар халтар хоёр зүйлийн зүсийг илүү эрхэмлэж, сүүлний үзүүр цагаан юм уу, бэлгэ тэмдэггүй хар нохойн зүсийг цээрлэх үзэл байдаг нь эрхлэх аж ахуйн уламжлалтай нь холбоотой. Нохойны зүсний тухайд ан агнуурын үед чонын зүстэй төсөөтэй шар зүсмийг эрхэмлэж байсан бол мал аж ахуйн соёлын үеэс дөрвөн нүдтэй хар халтар, улаан халтар нохой, зүрх цагаан хар нохойг хоточ нохойн эрхэм зүс гэж үзэх болжээ. Цээрлэдэг зүсний тухайд сүүлний үзүүр цагаан хар нохой тэжээх муу, Чөтгөр далладаг гэж үзэн сүүлний үзүүрийг тас хазах буюу цавчсаны дараа тэжээдэг бол бэлгэ тэмдэггүй тас хар нохойг маш муу гэж энэ зүснээс ихэд цэрвэдэг байна.

Зүрх цагаан хар нохой- Зүхэл хар тэнгэрийн бэлгэдэл болох нь

Монголчууд мөн зүрх цагаан хар нохой /чинаг нянгар/-г Зүхэл хар тэнгэрийн зараал гэж үзэх ба чөтгөрийн дарлага гэж эрхэмлэн тэжээдэг. Тиймээс “Буга”, “Үүчүүр” зэрэг ан агнуурын арга тактикийг тусгасан ардын уламжлалт хөлөгт болон хөзөр тоглоомуудад анч нохдыг дүрслэх ба эдгээр тоглоомыг тоглоход хий мууг үргэж зайлж байдаг гэж үзх нь бий. Олон монголчуудын дунд өргөн дэлгэрсэн хөлөгт тоглоом “Буга” бол монголчуудын ан агнуурын соёлыг тусгасан эртний уламжлалт өвөрмөц тоглоом юм. Буга тоглоомын олон хувилбар уламжилсан байдгаас Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр, Галт сумдад өдгөө тоглож буй 35 буудалт хөлөгтэй “Уул талын буга”-аар жишээ болгон хэлбэл, хоёр бугын эсрэг 24 нохой тавьж тоглодог. Тоглох журмын хувьд эхлээд 8 нохой тавиад, буга барьсан хүнээсээ эхэлж нүүх ба буга барьсан хүний зорилго аль болох олон нохойг тоглоомоос хасах, нохой барьсан хүний зорилго аль болох цөөн нохойны хохиролтойгоор бугыг хорьж барих, байцад шахаж оруулах явдал юм. Эхний найман нохой бол голын хөндийд бугыг отоож, бугын замыг хаахад буга нохойг устгаж эхэлдэг. Нохой барьсан хүн найман нохойныхоо араас шаардлагатай бол нохойгоо нэмж тавьсаар, тавих нохойгүй болбол хөлөг дээрээ нохдоо нүүх байдлаар бугыг байцад шахна. Сайн анчин бол арга мэх, ухаан зарж хожилд хүрдэг байхад туршлагагүй хүүхэд багачуул бол олон нохойгоор хөөж тоглодог.

Х.Дарамбазарын бичсэн нэгэн өгүүлэлд, “Бага бугыг наадахдаа хоёр хүн эсрэг тал болон арван цагаан, нөгөө нь арван хар нохойг өрөөд цагаан нохой авсан нь эхлэн өөрийн өрсөн арван нохойны түрүүчийн эгнээний таван цагаан нохойны аль нэгийг зөвхөн давших чиглэлээр нэг буудал ахиулан нүүнэ. Ингэхэд эсрэг наадагч нь мөн адил өөрийн нохдын түрүүчийн эгнээнээс аль нэг нохойг эсрэг талынхаа өмнөөс сөргүүлэн нүүнэ. Хэн нэгний нохой, эсрэг талынхаа аль нэг нохойтой зэрэгцээ буудалд айлсах тохиолдолд айлссан эсрэг нохойны эгц цаад талд сул буудал байвал давж хөлгөөс гарган иддэг. Идэх тохиолдол байхад идэхгүй өнгөрч болохгүй. Хэд хэдэн идэх боломж зэрэгцвэл нэг нүүдлээр олныг идэхдээ идэж буй нохойгоо идэлтийн эцсийн буудалд буулгасны дараа идээгээ нэгмөсөн авна. Тэгэхдээ нэг нохойны дээгүүр нэгээс илүү давах ёсгүй. Наадагч бүрийн хувьд хөлгийн хамгийн захын эгнээний буудлуудыг “дам” гарах буудал гэдэг. Тэдгээр буудлын аль нэгэнд эсрэг талаас нь хүрч буусан нохой “бэрс” болдог. Бэрс гэсэн нь барс гэсэн эртний монгол үг. Нохойдоо өгдөг нэр. Бэрс болсон нохой шулуун зураасны дагуу хаашаа ч, хэдэн ч сул буудал алгасан нүүх, идэх эрхтэй болдог. Хэрэв “нохой” нь дам гарах буудалд буулгүй зөвхөн дайран өнгөрч эргэн идсэн бол бэрс болсонд тооцогдохгүй. Нохой нь дамын буудалд бууж, эсрэг талаа нэг нүүсний дараа бэрсийн эрх эдэлнэ. Ийм журмаар наадсаар эсрэг талаа нэг нохойтой үлдээх буюу үлдсэнийг нь шахаж мадалсан нь хожих болно.” [Х.Дарамбазар. “Залуучуудын үнэн” сонин]. Энэ тохиолдолд хүү түлхэж бус, бас торгуудууд шиг чоно явуулж бус, харин нохой тавьж тоглож буйгаараа сонирхолтой хэдий ч тоглоомын гол баатар болох буга нь гээгдэж, нохдын хооронд, тэр дундаа тэнцүү тооны хар цагаан нохдын хооронд тэмцэл өрнөх болсон өвөрмөц хувирал ажиглагдаж байна.

Мөн Цагаан сарын шинийн нэгний өдөр халх, урианхай нарын хот айлын засал болгож тоглодог “Үйчүүр” тоглоомд олон зүйлийн ан амьтдыг шувуунаас эхлэн, туулай, хүдэр, буга, ирвэс, бар, арслан гэхчлэн ханшийн дэсээр нь өрж агнах байдлаар тоглохдоо анч нохой, харцага хоёрыг хамтад тоолдог. “Дүрсийг лангаар үнэлэх ба тоглоом эхлэхдээ арслангаар толгойлон ханш, дэсийн дарааллаар бүх

амьтдаа өрж тавихад “тус бүр 7 лангийн үнэтэй харцага 4 ш, тус бүр 12 лангийн үнэтэй нохой 3 ш орж, нийлээд 64 лан болдог. Тоглох журмын хувьд тоглогчид хоёр тал болж суугаад, ээлж дараагаар нийт 6 шоог орхиж, сангийн хөрөнгө буюу баян хангайн баялаг ан амьтдаас азын шооны буултаар дүрмийн дагуу хувь авч тоглодог ёстой.

Шооны нүд 4 хонхортой буувал нохой авахаас гадна, 2 таван нүд, 3 ташуу, 1 зургаан нүд буувал нохой, 5 ижил бараан нүд, улаангүй буувал мөн нохой, 5 ижил бараан нүд, улаантай буувал мөн “нохой хорьсон шувуу” гээд шувуу авах, 5 ижил бараан нүд, 1 хонхортой буувал “нохой хорьсон хонхор” гээд юу ч авахгүй байх гэх мэт журамтай байна. Улайлгын үед 5 ижил хар, эсвэл 4 хонхор буувал нохой, “ижил хар, 2 ижил хар, 1 өөр хар бол бас нохой авна. Энэ мэтээр ан агнуурын соёлыг тусгасан уламжлалт тоглоомуудад анч нохдын дүр тод туссан байх ба тоглоом нь мууг зайлуулах, үргээх дарлагын бэлгэдэл болж байдаг.

Шар нохой - нагац ураг хийгээд язгууртны бэлгэдэл болох нь

Хуучин уламжлалд язгууртнууд гэгээн шар зүсмийн нохой тэжээж, түүндээ “хойлго” гэж нэр өгдөг байжээ. Энэ тухай эрдэмтэд нэгэнт ажиглаж, “*Урьд цагт эзнийг нь элэгдэхээр хайртай нохой, морь зэргийг нь алж эзэнтэй нь хамт оршуулдаг заншил байсан тул монголчууд тийм нохойдоо “хойлго” нэр өгдөг байжээ. Нагацын хойлгод шар зүсмийн нохой тэжээдэг байсан учраас ингэж “нагацын шар нохой амална” гэж хэлсэн байж магадгүй*” /Ш.Гаадамба нар 1988, 198/ гэхчлэн бичсэн байна.

Гэхдээ “зөвхөн хан цагаан яс удамтай айл л шар нохой тэжээдэг, харц айл тэжээвэл ахадна” хэмээх үзэл ч бас байжээ. Бид баруун монголын олон ястнуудаас шар нохойн тухай асууж явахад, нэгэн хотон эмгэн “*Шар нохой манай угшил биш, тэжээх тэжээхгүй нэг учир бас байдагш. Манайх нэг тэжээсэнд ахадна гэж байнав. Аав ээжийн үеэс л таарахгүй юм байдагш*” хэмээн хуучилж байлаа. Энэ бол монголчуудын язгуурын шүтлэг - бөө мөргөлийн сүнсний тухай үзэл ойлголттой холбоотой төдийгүй, эртний монголчуудын оршуулгын ёс хийгээд хойлголох зан үйлээс уламжилсан зүйл байна.

“Монголын Нууц Товчоо”-гоор уламжилсан монголчуудын угсаа гарлын тухайт нэгэн домогт Тэмүүжинийг нагац нарт нь хүргэхдээ нохойноос цочдог хэмээн онцлон хэлдэг. Мөн Алангоо эхийн домогт “шар нохой” хэмээн домоглож, их хааны өвөг дээдсийн язгуур гарлын талаар өгүүлсэн өмнөх домгийнхоо үзэл санааг шууд тодотгон үргэлжлүүлсэн шинжтэй буюу “Монголын Нууц Товчоон”-д Бөртэ Чоныг дээр тэнгэрээс заяат төрсөн гэсний дараа Чингис хааны угсааг дахин чононоос гаралтай болгон бататгаж буй, сүлд шүтлэг /тотемизм/-ийн үзэл санааг тод тусгасан домог билээ /Г.Нандинбилиг, 2002/. Уг домгийг иш татвал “Монголын Нууц Товчоон”-д Добун мэргэнийг үгүй болсон хойно Алангоо эх гурван хөвгүүнийг төрүүлж Бэлгүнүтэй, Бүгүнүтэй хоёр ахмад хөвгүүн нь гэрийн дотор Маалиг Баяудай овгийн зарцаас өөр эр хүмүүн үгүй тул түүний ураг биз хэмээн эхийгээ сэжиглэн хэлэлцэхүйд Алангоо “sonit buri ceugen sira gu un ger-un eruge dotoqa-yin gege er oroju ke eli minu biliju gege en inu ke eli-tur minu singgegu bule e qaruran naran sara-yin kili yer sira noqai betu sicabaljuju garqu bule e” /Лигети 1971. 26/ гэхчлэн өгүүлдэг. Бөртэ Чонын домогт хүн чононоос хувилж үүссэнээр өгүүлдэг бол Алангоогийн домогт чоно нь хүн дүртэй ирээд шар нохойн дүрээр гарч одсоноор өгүүлж улмаар дараагийн улирал хувьсалд дахин чононоос хүн

буй болж Бодончар нар мэндэлсэн байдаг. Домог дахь “sira noqai” гэдэг нь чонын эерүүлэн цээрлэсэн нэр байж болзошгүй. /С.Дулам 1989.35/ хэмээн судлаачид үзсэн нь буй. “Монголын Нууц Товчоо” бол монголчуудын оюун санаанд эртнээс хадгалагдан ирсэн домог зүй, шүтлэг мөргөлийн баялаг сан хөмрөг мөн бөгөөд эл домгийн зүйлсийг судлан үзэхэд нагацын шүтлэгтэй холбогдож очиж байна.

Мөн түүнчлэн хүүхдийн ам гэмтэхэд “нагацын амгайн дом” хийгээд, дом авахгүй байвал “нохойн бөөсгөөр домнох” ёс байдаг. Захчингууд “Хүүхдийн амны гэм хүндэрвэл үүдээ онгойлгож байгаад босгоны дотор талд хүүхдээ зогсоож, босгоны гадна нохой хөнгөлж, халуун төмсгийг нь аманд нь хийж домнодог ба энэ домын дараа хүүхдийг хиншүү, салхи авахуулахыг цээрлэдэг байна Нагацын шүтлэг нь ийнхүү нохой шүтлэгтэй холбогдож буй явдал бидний сонирхолыг өөрийн эрхгүй татаж байгаа юм. Монголчууд “Нагацын эзгүйд нагацын шар нохой ахална” гэх буюу шөнө орой үсээ самнахыг ихэд цээрлэж, самнах хэрэг гарвал “Шар нохойн хуримд очих гэж байна” гэж хэлдэг дом ч байдаг. Энэ бүхэн нь нагацыг хүндэтгэхийг сургасан нэгэн утгаас гадна нагац нохой хоёрыг холбон сэтгэх өөр нэгэн учир сэжмийг агуулж байна. Нохойны эрхэмлэх зүс нь ч ямагт “шар нохой” хэмээн хэвшсэн байгаа нь санамсаргүй хэрэг биш байна. Бидний үзэхээр, монгол дом шившлэг дэх нагацын шүтлэг нь эхийн талыг хүндлэх заншил шүтлэгийн жишээ төдийгүй тэнгэр язгууртны “хойлгын” шар нохойгоор дамжин Бөртэ-Чонын шүтлэгтэй шууд холбогдож буй бөгөөд чинад язгууртаа монголчуудын Наран шүтлэг, гэрлийн шүтлэгт тулж очих нэн эртний улбаат үзэл ойлголт бололтой.

Долоо. Нохой – үнэнч зан чанарын бэлгэдэл болох нь

“...Нохой хань нөхөргүй гав ганцаар байв. Тэгээд ижил хань эрж явсаар чонотой тааралдаж гэнэ. ..Чоно түүнээс айж байхыг бодвол баавгай их хүчтэй амьтан байгаа байх гэж бодоод, ой модон дотор баавгайг эрж явсаар арай чүү олж уулзав...Нохой арслан гэж баавгайнаас хүчтэй амьтан байх нь түүнтэй очиж нөхөрлөе гэж санаад баавгайнаас салж явав...Нохой маргааш өглөө нь арсланг айлгадаг тэр хүн гэгч амьтантай нөхөрлөе гэж бодоод явав. тэгээд хүнтэй уулзаад : Би тантай хамт амьдрахаар ирлээ гэсэнд хүн дуртай зөвшөөрч хамт суух болов. Нэг шөнө нохой хуцаж гарсанд хүн босож ирээд: Туу туу гэж. Тэгээд нохой хүнээс илүү хүчтэй амьтан байдаггүй юм байна гэж бодоод хүнтэй нөхөрлөж одоо болтол хамт амьдарч байдаг гэнэ. МАДУ., 1989, 92

Нохой нь тэжээсэн эзэндээ үнэнч, барагтай бол урвадаггүй, олон жилийн дараа ч эзнээ таньж байдаг амьтан юм. Айлын нохойг урвуулж авах муу гэж үзэх ба эзэнтэй нохой урваж ирвэл хөөх ёстой байдаг.

Нохой нь нүүдэлчдийн амьдралд хэзээнээсээ ан агнуур, дайн байлдаан, гэр орноо хамгаалахад хүний үнэнч нөхөр болж иржээ. “Монголын нууц товчоо” дахь нохойны дүрийн өөр нэгэн бэлгэдэл бол түүний үнэнч хийгээд үл урвах зан чанарын тухай санаа юм. “Монголын нууц товчоо”-нд Чингис хааны зэв сүбээдэй, зэлмэ, хувилай өрлөг жанждыг “дөрвөн нохайс” гэж нэрлэсэн нь тэдний үнэнч хийгээд үл урвах зан чанарыг адилтгасан хэрэг юм.

Найм. Нохойн идүүр - айл гэрийн буян хишгийн бэлгэдэл болох нь

Нохойг эрхэмлэх үзлээс үүдэн нүүдэлчдийн гэрийн соёлд “нохойн идүүр”, “нохойн уяа”, “нохойн хүзүүвч”-ийг хүндлэх заншил бий болжээ. Нохойн

идүүрийг айл гэрийн буян хишигтэй холбон сэтгэж, хишгийн уутны адил буян хишгийн даллагын сав гэж үздэг. Нүүдлийн үед нохойн идүүрийг сүүлийн хөсгийн хамгийн дээр ачааллах ба нохойн идүүр дээгүүр алхдаггүй, нохойн идүүр хагарвал айл гэрийн буян хишиг хомстохын ёр гэж үздэг бол нохойн уяаг буяны аргамжаа гэждэг. Энэ нь хүн малаа бараад хангайнахаас хар тогоотой, гангинахаас ганц нохойтой үлдэх цагт нохойн уяа, нохойн хүзүүвч буян хишгийг далладаг гэсэн домтой. Нохойн уяаг гэрийн гадна нохой зүгт модон гадсыг газар ухаж суулгаад, амгүй төмөр гинжээр гүйлгэн эргүүлэгтэй бэхэлдэг бол нохойн хүзүүвчинд гал улаан бөс даавуугаар нохойн хэлийг дуурайлган хэлхээ гурвалжин хэл эсгэж цацаг болгон оёсон байна. Нохойн хүзүүвч нл нохойд сүр хүч оруулж, эзэнтэй нохой гэсэн тэмдэг болдог.

Ес. Нохойг нэрээр бэлгэдэх нь

Монгол нохойн нэрийг авч үзвэл, үлгэр туульсад Асар Басар нэрт ноход гардаг бол хоточ нохойд Арслан, Барс, Баавгай, Банхар, Хүдэр гэх мэт сүрэглэдэггүй хүчирхэг амьтдыг бэлгэдсэн нэр өгөхөөс гадна Хойлго, Өлзий, Зоосоо гэх мэт зан үйл, бэлгэдлийн нэрийг өгөх, Чинаг, Нянгар гэх буюу зүрх цагаан гэсэн бэлгэдэл нэрүүдийг өгөх нь ч элбэг байдаг бол хүнд Муунохой, Сайннохой, Нохойцагаан гэх мэт нэрийг өгч эндүүрүүлэх дом болгодог ёс бий. Нохой тэжээж буй айл нь нохойдоо хүний нэгэн адил оноосон нэр өгч өрх бүлийнхээ тоонд оруулсныг харуулна.

Ан агнуурын соёлын үед нохойг олноор тэжээдэг байсан бол мал аж ахуйн соёлд шилжсэнээр нэг хот айл, нэгэн жалгад нэг үүрний буюу нэг жингэрийн гөлөгнүүдийг хамт тэжээдэггүй, эзнээ барина гэж цээрлэдэг. Аргагүй тэжээх болбол нүдийг нь боож төөрүүлэн авчирч болгоомжтой тэжээнэ.

Дүгнэлт

1. Монгол ардын бүтээл туурвилын домог зүйд Бурхан хүнийг бүтээн туурвих үед нохой нь хүнийг Чөтгөрөөс хамгаалах үүрэгтэй бүтээгдсэн боловч хоолонд ховдогсноос болж сэрэмж алдсан тул “Хүйтэнд яс мэрж, хүний муу сайныг идэж, зодуулж яв”, “Нүүхэд явган дагаж, нүцгэн яс мэрж яв”, “Саранд сэрж, наранд дулаацаж яв” гэсэн Бурханы зүхэлд унаж, шийтгэгдсэн дүр бөгөөд чухам иймээс өлөн ховдгийн бэлгэдэл дүр болжээ.

2. Монгол домог зүйн нохой нь хүний мөнх наслах хутгийг алдуулсан буруутай учир хүний өмнө амин насны өр төлөөстэй болсон домог зүйн архетип дүр бөгөөд “Сайн нохойн үхэл эзнээ хаана” гэсэн хэлц бий болж, нохойн үхэл нь хүний амин насны бэлгэдэл болсон байна.

3. Домог зүйн дараагийн улирал хувиралд шар зүсмийн нохой нь язгууртны оршуулгын соёлтой холбогдож, нийгмийн статусын бэлгэдэл болсон бол Зүхэл хар тэнгэрийн зараал, зүрх цагаан хар нохой нь чөтгөрийн дарлага, Зүхэл хар тэнгэрийн бэлгэдэл, дөрвөн нүдтэй халтар нохой нь “далдыг харагч, бэрхийг сахигч” бэлгэдэлтэй дүр болсон байна.

4. Хүн, нохой хоёрын харилцаа гүнзгийрэн хөгжихийн хэрээр домгийн нохой нь ёс заншлын нохой болсон бөгөөд нохойн дүрийн бэлгэдэл утга улам бүр баяжсаар нохойгоор хүний сонор сэрэмж хийгээд үнэнч нөхөрлөлийг бэлгэдэх болжээ.

5. Нохойг эрхэмлэх үзлээс үүдэн, нохойн идүүрийг буян хишгийн сав гэж бэлгэдэхийн зэрэгцээ нохойд өгөх оноосон нэрийн бэлгэдэл утга олон зүйл агуулгаар баяжин хөгжсөн байна.

Ном зүй

Гадаад хэлээр

- Bianquis, I., F. Aubin & D. Sendenjav. (2013). Le chien et la bru, deux être liminaires en Mongolie, in K. Buffetrille, J.-L. Lambert, N. Luca & A. de Sales (eds.), *D'une anthropologie du chamanisme vers une anthropologie du croire. Hommage à l'œuvre de Roberte Hamayon.* (pp303–323). (Etudes mongoles et sibériennes, centrasiatiques et tibétaines, hors-série.) Paris: Centre des Etudes Mongoles & Sibériennes/ Ecole Pratique de Hautes Etudes.
- Gaby, Bamana. (2014). Dogs and Herders: Mythical Kinship, Spiritual Analogy, and Sociality in Rural Mongolia. *SINO-PLATONIC PAPERS*, Number 245.
- Humphrey, C. (1976). Some notes on the role of dogs in the life of Mongolian herdsman. *Journal of the Anglo-Mongolian Society* 3(2): 14–23.
- Humphrey, C. (2013). The fateful landing of the hoopoe: omens, cosmology and social fractures in Mongolian regions. Paper presented at the workshop 'The Hiccups of Social Life!', Cambridge, May 2013.
- Jamtsarano, Ts.J. (1965). Halha Jirum, Pamyatnik Mongol'skogo Feodal'nogo Prava XVIII v. [Halha Jirum, A Monument of XVIII Century Mongolian Feudal Law]. Moscow: Nauka, glav. red. vostochnoi lit-ry.
- Terbish, B. (2015). The Mongolian Dog as an Intimate 'Other'. *Inner Asia*, 17(1), 141-159. <https://doi.org/10.1163/22105018-12340037>.

Монгол хэлээр

- Арьяасүрэн Ч, Нямбуу Н (1991). Монгол ёс заншлын тайлбар толь. Улаанбаатар: Сүүлэнхүү хэвлэлийн газар
- Гаадамба Ш. Цэрэнсодном Д. (1978) Монголын ардын зохиолын дээж бичиг. Редактор Ц.Дамдинсүрэн, Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар
- Дулам С. (2019). Монгол домог зүйн дүр. (Нэмж зассан хэвлэл), Ариутган шүүсэн Д.Бум-очир, Улаанбаатар: Битпресс. (Анхны хэвлэл 1989)
- Монгол ардын домог үлгэр (1989) Эмхтгэсэн Д.Цэрэнсодном. Редактор Х.Сампилдэндэв нар, ШУА., ХЗХ., Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар
- Нандинбилиг Г. (2002). “Монголын нууц товчоо” дахь улбарих хувилах өгүүлэмжийн тухайд. Өвөр монголын үндэсний их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл. 2002 оны 1-р хугацаа (№ 76). 16-21.
- Нандинбилиг Г. (2004). Монгол дом шившлэг ба нагацыг шүтэх ёсон. Монгол судлал МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг, XXIII боть, 216-220.
- Нандинбилиг Г.(2008). Монгол тоглоомын зан үйл, бэлгэдэл. Нүүдэлчдийн өв Монголын үндэсний музейн ЭШ-ний сэтгүүл. Tomus VIII, Fasc17, 190-202.
- Нандинбилиг Г. (2009). “Буга” тоглоомын зан үйл, бэлгэдэл. Монгол судлалын чуулган. МУБИС-ийн эрдэм шинжилгээний цуврал. № 7 \42\, 143-150.
- Сэржээ, Ж (2013). Монгол нохойн нэрийн тухай. Оюуны хэлхээ Антоон Мостарт Монгол судлалын төвийн эрдэм шинжилгээний сэтгүүл. I (09) 211–213.
- Шүрхүү, Ч. (2011). Монгол улсын цагдаагийн эрэлч нохойн түүх. Улаанбаатар: Адмон пресс.
- Шүрхүү, Ч. (2011). Даяаршаагүй монгол нохой. Улаанбаатар: Адмон пресс.

Abstract

The symbolism of dogs in Mongol myths is analyzed in this paper by explaining the meanings of Mongolian idioms through mythological narratives. According to Mongolian myths, the dog is an archetypical character that becomes indebted to humans after being remiss with his duties. The dog is depicted as a creature that owes a life to humans, and only by devoting his life to the good of humans can he be liberated from the burden and entitle himself to be reincarnated as a human. In the creation myth, the dog's character is depicted as a casualty in the conflict between God and the Devil that transpired during the process of human creation. Although the dog was tasked to protect humans from the Devil, he neglected his duties and was punished by God.

During the domestication of dogs, yellow-coated dogs became a symbol of social status and were deeply tied to aristocratic culture. As the relationship between humans and dogs deepened, the mythical dog became the dog of traditions, enriching the dog's character. Mongolians started to symbolize loyalty and vigilance through the dog.